



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 3 сарын 20 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Г Оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн оноосон нэрийг “Үндэсний давхар даатгал” ХК болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан компанийн бизнес төлөвлөгөөг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шинэчлэн боловсруулж, Даатгалын тухай хуулийн 55.1-д заасан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК /Г.Энхтайван/-д үүрэг болгосугай.
3. Оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгүүдийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 10 хоногийн дотор ирүүлэхийг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК /Г.Энхтайван/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /М.Өлзийбат/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН